



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/266

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.б, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 298 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлын албаны 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл шинээр олгох нэр бүхий 1 аж ахуйн нэгжийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл сунгах нэр бүхий 12 аж ахуйн нэгжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон болон сунгасан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б. Мөнх-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100565

Аймгийн Засаг даргын 2021 оны.....⁰⁶
дугаар сарын 04.-ны өдрийн ^{Ар/06} дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, ЧИГЛЭЛ, ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУГАЦАА

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1	Нинжин тун хувийн эмийн сан	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум 13 дугаар баг	Шинээр олгох	3 жил

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны.....
 дугаар сарын 04.-ны өдрийн А/268 дүгээр
 захирамжийн хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
 ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
 НЭР, ЧИГЛЭЛ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУГАЦАА

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа
1	Эрдэнийн толь клиник	Дүрс оношилгоо, хүүхдийн тусламж үйлчилгээ	Хархорин сум	Сунгах	5 жил
2	Оточ энэрэхүй клиник	Эмэгтэйчүүд, мэс засал, дүрс оношилгооны тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
3	Хашийн увидас клиник	Сэргээн засах, Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
4	Гэрэлт-Амарлингуй клиник	Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
5	Итгэл сэтгэл клиник	Хүүхэд, дүрс оношилгоо тусламж үйлчилгээ	Бат-Өлзий сум	Сунгах	5 жил
6	Агь Манба клиник /ортой/	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
7	Уян сэтгэл Өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
8	Наран мед клиник	Мэдрэл, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
9	Баялаг түвшин хувийн эмийн сан	Эмийн сангийн үйлчилгээ	Уянга сум, Жаргалант баг	Сунгах	5 жил
10	Виктория хувийн эмийн сан	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
11	Эм гоо хувийн эмийн сан	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил
12	Мөнхбулаг хувийн эмийн сан	Эмийн сангийн үйлчилгээ	Арвайхээр сум	Сунгах	5 жил